



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**



АГУУЛГА

1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт.....	1
2. Санхүүгийн тайлангийн аудит.....	3
3. Гүйцэтгэлийн аудит.....	9
4. Нийцлийн аудит.....	13
5. ИТХ-ын хүсэлт, өргөдөл, гомдолд хийсэн аудитын дүн.....	14
6. Дотоод ажил.....	15
7. Дотоод сургалт.....	18
8. Санхүү тайлагнал, төсвийн гүйцэтгэл.....	29
9. Дүгнэлт, санал.....	30
10. Статистик мэдээ.....	31
11. Албан шаардлага.....	38
12. Акт.....	40
13. Сарын мэдээ.....	45
14. Санхүүгийн тайлан.....	51

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 онд МУ-ын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын Олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Энэ онд Төрийн аудитын тогтолцооны аудитын чанар үр өгөөжийг дээшлүүлэх жил болгох зорилтыг дэвшүүлж, удирдах ажилтны зөвлөгөөнөөс гаргасан шийдвэр, зөвлөмжийг нийт ажилтнуудад танилцуулж 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажилласан.

2018 оны эхний хагас жилд УАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 3, аймгийн ИТХ-ын захиалгаар 1, өөрсдийн санаачилгаар 1, нийцлийн 1, нийт 6 нийцэл болон гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитаар 66 төлбөрийн актаар 40.0 сая төгрөгийн төлбөр тогтоож 42 акт бүрэн барагдаж, төсөвт 26,2 сая төгрөг оруулж, 28 хүн 865 өдөр, 458 цаг илүү ажилласан байна.

Аудитаар илэрсэн зөрчил дутагдалд 4650,4 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 560,3 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаа. Өмнөх оны үлдэгдлээс 5 албан шаардлагын 2 албан шаардлагыг хэрэгжүүллээ.

Эхний хагас жилийн байдлаар хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж 5834.3 сая төгрөг, нийт 251 зөвлөмж өгснөөс 46 зөвлөмж хэрэгжсэн байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар батлагдсан 13 орон тоогоор ажиллаж байна. Үүнээс Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч 8, бизнесийн ухааны магистр 3, хууль, эрх зүйн ухааны магистр 2, эдийн засгийн ухааны магистр 2, нийт 7 магистр ажиллаж байна.

Нийт албан хаагчдын 46,2 хувь нь Төрийн аудитын байгууллагад 9 жилээс дээш ажиллаж байгаа туршлагатай аудиторууд байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторoor Ч.Чүлтэмбат, хэлтсийн дарга, аудитын менежерээр Ш.Мөнхбаяр, санхүүгийн аудитын ахлах аудиторoor С.Батцэцэг, гүйцэтгэлийн аудитын ахлах аудиторoor Ш.Ганчимэг, нийцлийн аудитын ахлах аудиторoor Х.Сувдмаа нар ажиллаж, байгууллагын удирдлагын зөвлөлийн багийг бүрдүүлж байна.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг дүгнэхэд манай хамт олон 4-р байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ
АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ							
№	Аудитын сэдэв	Хамрагдах байгууллага	Эхлэх	Дуусах	Аудит хийх баг	Төлөвлөгөө	Аудит хийх аудитор
1	2017 оны Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн	ХБТХэлтэс	2018.01.02	2018.04.20	ГАБ	Нэгдсэн удирдамжаар	Г.Батмямар, Ч.Гантулга, Н.Отгонцэцэг
2	Дархан-Уул аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	СТСХ	2018.03.20	2018.04.20	САБ	Нэгдсэн удирдамжаар	У.Батсүрэн, Х.Сувдмаа
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудад аудит хийх	ХБТХэлтэс	2018.01.01	2018.03.20	ГАБ	Нэгдсэн удирдамжаар	Д.Отгонбаяр, С.Санжаажав
4	Төрийн сангийн үйл ажиллагааны тогтолцоо, үр дүн	СТСХ	2018.06.15	2018.11.15	САБ	Нэгдсэн удирдамжаар	Ш.Ганчимэг, Н.Отгонцэцэг
5	Аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны үр дүн	Татварын хэлтэс	2018.04.01	2018.06.15	ГАБ	Аймгийн ИТХ-ын захиалгат	Ш.Ганчимэг, Ч.Гантулга, Д.Отгонбаяр, Н.Отгонцэцэг
6	Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн үйл ажиллагааны үр дүн	Нэгдсэн эмнэлэг	2018.05.01	2018.09.10	ГАБ	Өөрсдийн санаачлагаар	С.Батцэцэг, С.Санжаажав, Г.Батмямар
7	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2016-2017 оны үйл ажиллагаа	Цэцэрлэгүүд	2018.09.01	2018.11.10	ГАБ	Өөрсдийн санаачлагаар	С.Батцэцэг, У.Батсүрэн, Д.Отгонбаяр
ХОЁР: НИЙЦЛИЙН АУДИТ							
1	Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн	Сумдууд, ХБТХ	2018.09.01	2018.12.01	НАБ	Нэгдсэн удирдамжаар	Х.Сувдмаа, Г.Батмямар
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	ТЕЗ, ТТЗ, ТШЗ	2018.10.01	2018.11.15	НАБ	Нэгдсэн удирдамжаар	С.Санжаажав
3	2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц	ТЕЗ, ТТЗ, ТШЗ	2018.09.01	2018.12.01	САБ	Нэгдсэн удирдамжаар	Ч.Гантулга,
4	Боловсрол, соёл урлагын газрын 2016-2017 оны үйл ажиллагаа	БСУГ	2018.10.01	2018.11.30	НАБ	Аймгийн ИТХ-ын захиалгат	Ш.Ганчимэг, Н.Отгонцэцэг
5	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүн	Улсын бүртгэл	2018.11.01	2018.12.20	НАБ	Аймгийн ИТХ-ын захиалгат	С.Батцэцэг, У.Батсүрэн, Д.Отгонбаяр
6	ТӨХК-уудын Худалдан авах ажиллагааг хэрхэн хуульд нийцүүлэн явуулж байгаа байдал, үр дүн	ТӨХК-үүд	2018.04.20	2018.07.10	НАБ	Өөрсдийн санаачлагаар	Х.Сувдмаа, У.Батсүрэн, С.Санжаажав

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2018 ОНД ХИЙХ ДОТООД СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хичээлийн сэдэв	Хугацаа	Хичээл заах албан хаагч
1.	Санхүү тайлангийн аудит	I улирал	С.Батцэцэг
2.	Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм		Ш.Мөнхбаяр
3.	Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрэм		Ш.Мөнхбаяр
4.	Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэх ёс зүйн ерөнхий хэм хэмжээ		Ш.Мөнхбаяр
5.	2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар илэрсэн залруулагдсан болон залруулагдаагүй НББ-ийн бичилт №01	I улирал	У.Батсүрэн
6.	2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар илэрсэн залруулагдсан болон залруулагдаагүй НББ-ийн бичилт №02		У.Батсүрэн
7.	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал цуврал хичээл №01	II улирал	С.Батцэцэг
8.	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал цуврал хичээл №02		С.Батцэцэг
9.	Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал цуврал хичээл №03		С.Батцэцэг
10.	Санхүүгийн тайлангийн аудитыг богино хугацаанд хийж гүйцэтгэх нь		С.Санжаажав
11.	Төрийн албаны нууцын тухай хууль	III улирал	Ш.Мөнхбаяр
12.	“Аудитын үр өгөөжийг төлөвлөх, бүртгэх, тайлагнах, хянах мэдээлэх журам” сургалт		С.Санжаажав
13.	“Худалдан авах ажиллагааны аудит” сургалт	III улирал	Ч.Гантулга
14.	Хараат бус байдлыг хангах шаардлагыг хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй		Ч.Гантулга
15.	Аудитад залиланттай холбоотой аудиторын үүрэг хариуцлага		У.Батсүрэн
16.	Аудитыг төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдал АДБОУС 320, 1320	IV улирал	Д.Отгонбаяр
17.	Аудитын эрсдэлийн үнэлгээ АДБОУС 315, 1315		Ч.Гантулга
18.	Нийцлийн аудитын тулгуур зарчим, стандарт	IV улирал	Х.Сувдмаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 – 8.9.8 дахь заалтууд, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төсвийн шууд захирагчдын 115, төвлөрүүлэн захирагчдын 5, ерөнхийлөн захирагчийн 1, тусгай сангийн 4, төсөл хөтөлбөрийн 1, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 16, нийт 142 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийлээ. Эдгээрийн 68 аудитыг Төрийн аудитын байгууллага, 74-ийг гэрээгээр хувийн аудитын компаниар гүйцэтгүүлсэн ба итгэл үзүүлсэн болон түүвэрт хамруулсан байгууллага байхгүй болно.


Аудит хийхдээ УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын 2005 оны 275, 2006 оны 388, 2011 оны 48, 2012 оны 276, 2013 оны 73, 269 дугаар тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аргачлал заавар, журам, МУ-ын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам” гарын авлагын арга зүйгээр СТАУС программыг ашиглан санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргахдаа найдвартай, учир холбогдолтой, зохистой нотлох баримтад тулгуурлан дүгнэлт өгөв.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар нийт 10,453.7 сая төгрөгийн алдааг илрүүлэн, 5,159.7 сая төгрөгийн алдааг залруулж, 35.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 153.3 сая төгрөгийн албан шаардлага өгч, 5,099.8 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгчээ.

2018 онд илрүүлсэн нийт алдаа зөрчил 2016 оноос 4 дахин, 2017 оноос 2.6 дахин өссөн бол төлбөрийн акт, албан шаардлага 2016 оноос 4 дахин, 2017 оноос 2.4 дахин тус тус нэмэгдсэн байна.

Аудитад нийт 142 байгууллага хамрагдаж, 140 зөрчилгүй стандарт дүгнэлт, 1 дүгээр сургууль, Энэрэл цогцолбор сургуулиуд хязгаарлалттай дүгнэлт авсан байна.



2.1.Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн дүн



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



Ерөнхий менежер болон СТСХ-ээс төсвийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд зохих хяналтыг хэрэгжүүлж ирсэн ч дараах зөрчлүүд илэрч байна.

Аймгийн ЗДТГ баяр наадам, ойн арга хэмжээ, уралдаан тэмцээнд 12,279.1 мянган төгрөгийн зардал гаргасан, Дархан сумын ЗДТГ нөөц сангийн зардлаас 17,771.2 мянган төгрөгийг сар шинийн баяр, сургалт, уралдаан тэмцээнд зарцуулсан, тушаал шийдвэргүйгээр 7,791.3 мянган төгрөгийн засварын гэрээ байгуулсан, сумын Засаг дарга дээд шатны удирдах байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр гадаадад томилолтоор ажилласан, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон, Хонгор сумын ИТХ 3,600.0 мянган төгрөгийн урсгал засвар хийсэн, Орхон сумын ИТХ болон ЗДТГ-ын санхүүгийн тайлангуудын уялдаа

холбоо 15,082.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн, авлага, өр төлбөр үүсгэсэн, зэрэг дэвийн нэмэгдлийг илүү олгосон, элэгдлийн зардлыг 18,878.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсон, Шарын гол сумын ЗДТГ 23,314.1 мянган төгрөгийн нөөцийн барааг хангамжийн материалаар бүртгэсэн, аймгийн ЗДТГ 9,023.9 мянга, Дархан сумын ЗДТГ 16,532.1 мянган төгрөгийн авлагатай ажилласан, НААҮГ 9,000.0 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын дүн нярвын болон тооллогын дүнгээс 534,347.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, Хонгор сумын ЗДТГ хандив тусламжаар хийгдсэн хөрөнгийг 43,140.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, анхан шатны баримтгүй 5,065.5 мянган төгрөгийн гүйлгээг зардлаар бүртгэсэн, мөн урсгал засвар хийсэн, Дархан сумын ОНХС 251,161.4 сая төгрөгийн авлагыг тайланд тусгаагүй, 165,623.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийгдсэн дүнгээс 3,180,863.6 мянган төгрөгөөр зөрүүтэй, 4 сумын сум хөгжүүлэх сан 485,060.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, Бохир усны менежмент төсөл тендерийн орлогоос 2.106,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч тайлант үеийн зардлаар бүртгэсэн, хөлсөөр ажиллах гэрээг Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалд нийцүүлээгүй, 25,521.2 мянган төгрөгийн бараа материалыг шууд зарлага болгосон зэрэг алдаа, зөрчлүүд илэрлээ.

Түүнчлэн орон нутгийн өмчит газруудад анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэх, цалин илүү олгох зэрэг зөрчлүүд нийтлэг байгаагаас гадна “Эмтнаран” ОНӨААТҮГ үндсэн үйл ажиллагааны 18,218.7 мянган төгрөгийн ажил гүйлгээ болон 24,947.6 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг татварын тайланд дутуу илэрхийлсэн, 2,000.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ ур чадварын нэмэгдлийг шийдвэргүйгээр олгосон, “Дархан Ус суваг” ОНӨХК найдваргүй авлагын зардлыг НББ-ийн бодлогын баримт бичигт зааснаар тооцоогүй, хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг бүртгээгүй, ТУЗ-ын баталсан төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн дүн



Дархан-Уул аймаг дахь Улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудын аудитаар 2,920.9 сая төгрөгийн алдааг илрүүлэн, аудитын явцад 1,082.6 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 16.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 31.1 сая төгрөгийн албан шаардлага өгч, залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх талаар 1,784.9 сая төгрөгийн зөвлөмж өгч, цаашид засаж сайжруулах асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

Улсын бүртгэлийн хэлтэс үндсэн хөрөнгийн элэгдлийг 5,638.9 мянган төгрөгөөр илүү тооцсон, тушаал шийдвэргүйгээр 15,143.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан, 2,951.1 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шийдвэргүйгээр

илүү цагийн хөлс олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон, сонгуулийн зардлаас 142.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан, хоол унааны хөнгөлөлт болон шатахууныг давхардуулан олгосон, өмнөх оны зардлыг тайлант оны зардлаар оруулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй зардлыг бүртгэсэн, Онцгой байдлын газар 31,413.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн санхүүгийн тайлан дахь дүн ерөнхий дэвтрийн дүнгээс 631,954.7 мянган төгрөгөөр зөрүүтэй, өмнөх үеийн үр дүнг 34,170.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон, цалингийн шатлал ахиулсан, 24,791.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг материалын тайланд тусгаагүй, үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй, Зэвсэгт хүчний 322 дугаар анги орлого, зардлын дансыг бууруулах бичилт хийсэн, нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэмжээр тайлант хугацааны орлого, зардлыг нэмэгдүүлсэн, ШУТИС түрээсийн орлогын 1,653.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй, санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгыг бэлтгээгүй, 10,177.4 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүлэн бүртгэсэн, ХААИС батлагдсан төсвөөс хэтрүүлэн 33,116.8 мянган төгрөгийн зардал гаргасан, 11,808.0 мянган төгрөгийн материал, 68,674.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тооллогод хамруулаагүй, 298.9 мянган төгрөгийн томилолтын зардал илүү олгосон, МСҮТ ээлжийн амралтын хугацаанд хавсран ажилласны нэмэгдэл олгосон, шатахуун унааны зардал давхардуулан өгсөн, мэргэшлийн зэргийн хугацаа сунгагдаагүй байхад нэмэгдэл авсан, 4,251.0 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан, ХХААГ цэвэр мөнгөн гүйлгээг 7,433.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, урсгал засвар хийсэн, санхүүгийн тайлангийн тэнцэл 5,358.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, 9,301.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, Цагдаагийн газар үндсэн хөрөнгийн элэгдлийг хүчингүй болсон тогтоолоор тооцож байгаа, 16,215.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсан, УГТХүрээлэн 112,904.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн, 365,986.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн, 31,614.1 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, 73,463.5 мянган төгрөгийн зардлыг шууд зардлаар бүртгэсэн, ур чадварын нэмэгдлийг илүү олгосон, малын нас дэвшилтийг бүртгэдэггүй зэрэг зөрчлүүд гарч байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын асуудал, дансанд буюу тайлангийн элементүүд, санхүүгийн тайлан гаргалтын талаар аудитын үед илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн нөлөөлөл буюу үр дагавар, алдаа зөрчлийг засаж арилгах, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах, хяналт удирдлагыг сайжруулахаар нийт 61 зөвлөмж өгсөн.

2.3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн дүн



Тус аудитад боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын 80, Эрүүл мэндийн сайдын багцын 8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Барилга, хот байгуулалтын сайдын багцын тус бүр 1, нийт 90 байгууллага хамрагдаж, урсгал зардалд 34,185.7 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 34,088.6 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 97.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 944,128.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 238,487.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 568,095.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөрчлийг арилгуулах 87 зөвлөмжийг өгч, 15,758.8 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах акт тогтоож, 121,786.6 мянган төгрөгийн

албан шаардлага өгөв. Бидний илрүүлсэн дээрх алдаа зөрчлийн дүн нь тогтоосон материаллаг түвшингээс хэтрээгүй болно.

Аудитаар дээрх байгууллагуудаас батлагдсан төсвийг хэтрүүлсэн байгууллага байхгүй, “Энэрэл” цогцолбор сургууль болон 1 дүгээр сургууль “Хязгаарлалттай”, бусад байгууллагуудад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, аудитаар доорх алдаа зөрчлүүдийг илрүүлээ.

- Урьд онуудад өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, тэтгэвэр тогтоолгосон 9, 14, 23 дугаар цэцэрлэгүүдийн эрхлэгч, 18 дугаар цэцэрлэгийн ажилтан, 11 сургуулийн захирал нарт 103.3 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон боловч тухайн албан тушаалаас чөлөөлөөгүй,
- Аймгийн Засаг даргын захирамжгүйгээр 1, 6, 7, 9, 11, 13, 14, 15, 16, 17, 21, 22 дугаар цэцэрлэгүүд, 30 дугаар сургууль, “Жигүүр” цогцолбор сургууль, Музей, Номын сан зэрэг байгууллагын удирдлагуудад 10.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,
- 9, 11, 16, 23, 24 цэцэрлэгүүд, 1, 9, 11, 14, 30, “Энэрэл” цогцолбор сургуулиуд, Орхон сумын ЭМТ, Биеийн тамир спортын хороо, Музей, Номын сан зэрэг байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлд заасныг зөрчиж, сахилгын шийтгэлтэй ажилтнуудад нэг удаагийн шагнал, урамшууллын зардалд 5.5 сая төгрөг зарцуулсан,
- Удирдлага, санхүүгийн ажилтны хариуцлагагүйгээс 3, 4, 5, 10, 12, 23 дугаар цэцэрлэгүүд, 1, 9 дүгээр сургуулиуд, Хүүхдийн номын ордон, Музей, Номын сан зэрэг байгууллагууд 4.4 сая төгрөгийн цалин, нэмэгдэл хөлс, тэтгэмж илүү тооцож олгосон,
- 14 дүгээр сургууль батлагдаагүй орон тоонд ажил хавсруулж 3.7 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн музей болон 12 дугаар цэцэрлэг цалингийн шатлал ахиулсан байна.

Иймд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд ТШЗ нарт шинээр батлагдсан болон өөрчлөгдсөн хууль тогтоомж, журам зааврын талаарх мэдээллээр хангах, мөрдөж ажиллах үүрэг даалгавар өгөх, санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах шаардлагатайг анхааруулсан болно.



Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2014 оны 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалтын дагуу Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагуудын судалгааг гаргаж, ҮАГ-т хүргүүлээ.

Судалгаагаар Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд 1 төсвийн ерөнхийлөн захирагч, 6 төсвийн төвлөрүүлэн захирагч, 28 төсвийн шууд захирагч, 83 тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага, 1 төсөл хөтөлбөр, 15 орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, нэгдмэл удирдлага /босоо бүтэц/-тай байгууллагуудад 32 төсвийн шууд захирагч, 3 засгийн газрын тусгай сан, 1 төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага байна.

2018 онд нэгдсэн удирдамжаар 4, аймгийн ИТХ-ын захиалгаар 1, өөрсдийн санаачилгаар 2 нийт 7 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилд төлөвлөгөөнд туссаны дагуу 275 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан 3 аудитыг хийж, 1 аудит хийгдэж байна.

Гүйцэтгэлийн аудитаар тайлант хугацаанд зөрчил арилгуулах 4,4 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч 10,3 хувийг хэрэгжүүлжээ.

Гүйцэтгэлийн аудитаар тайлант хугацаанд өгсөн 9 зөвлөмж, өмнөх оноос шилжиж ирсэн 11 зөвлөмж, нийт 20 зөвлөмжийн 50 хувийг хэрэгжүүлсэн байна.

3.1.Татварын хэлтсийн үйл ажиллагааны үр дүн



Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан 2017 оны төсвийн тухай хуулиар Дархан-Уул аймгийн орон нутгийн суурь орлогыг 15,192.4 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ 3,430.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,622.7 сая төгрөгөөр баталжээ. Аймгийн ИТХ 2017 онд орон нутгийн төсөвт 4 удаа тодотгол хийж, нийт орлогыг 3,048.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 21,671.4 сая төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн төсвийн орлого 2012 оноос хойш 7,811.2 сая төгрөгөөр буюу 55 хувиар нэмэгдэж байгаа боловч тухайн жилд тодотгох үндэслэл нь төсвийн орлогын төлөвлөлттэй бус, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зарлагатай уялдуулж нэмэгдүүлдэг байна.

2016 оны татварын ногдуулалт 25,962.4 сая, оны эхний татварын өрийн дутуу 8,309.7 сая, илүү 5,080.0 сая, хүлээгдэж буй гүйцэтгэлээр барагдуулалт 23,630.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байхад 2017 онд орлогыг 18,622.7 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь орон нутгийн татварын орлогыг үндэслэл муутай боловсруулсныг харуулж байгаа ба үүнийг 4 удаагийн төсвийн тодотгол ч баталж байна. Татварын тайлан, хяналт шалгалтын актаар тайлант оны татварыг ногдуулахын зэрэгцээ хөндлөнгийн мэдээллийг ашиглаж төлбөр ногдуулж байна.

2017 оны жилийн эцсийн татварын тооцооллын үлдэгдлийг хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулаагүй байгаа тул ТБМНС-аас татварын тооцооллын товчоог авч үзэхэд татварын тайлангаар 13,484.0 сая, татварын хяналт шалгалтаар 445.7 сая нийт 13,929.7 сая төгрөгийн өр бүртгэгдсэн байна. Нийт өрийн 9,906.1 сая төгрөг буюу 71.1 хувь нь тайлант оных бол 4,023.6 сая буюу 28.9 хувь нь өмнөх оны өр байна.

Тайлант онд 84,560.8 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээлэл ашиглан илрүүлсэн 2,078.2 сая төгрөгийн зөрчилд 204,9 сая төгрөгийн татвар ногдуулсан нь илрүүлсэн зөрчлийн 9.9 хувь буюу шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж ТЕГ-ын дотоод хяналт шалгалтаар дүгнэгдсэн байна.

Аудитын явцад тус хэлтсийн ТБМНС-д суутган-1 татварын тайлангаар татвар суутгаагүй орлого олсон татвар төлөгч иргэдийн жагсаалтаас 13 татвар төлөгчийн татварын барагдуулалтыг түүвэрлэн шалгахад 3 иргэний орлогын мэдээллийг холбогдох газруудад шилжүүлсэн, 5 иргэн төлсөн, 3 иргэн тайлан өгөөгүй, “Дархан-Ус суваг” ХК-д бараа, ажил үйлчилгээ нийлүүлсэн 2 иргэний регистрийн дугаар зөрснийг залруулаагүй, “Түмэн буудай” ХХК-аас олсон 1 иргэний 183.4 сая төгрөгийн орлогод ногдуулсан 2.1 сая төгрөгийн татвар одоо болтол барагдаагүй байна.

Үр дүнгийн гэрээний үнэлгээгээр 2017 онд 16 ажилтны албан тушаалын цалингийн шатлал ахиулж, төсвөөс 1,045.2 сая төгрөг зарцуулсан нь зарим ажилтны хувьд үр дүнгийн урамшуулал олгосонтой давхацсан бөгөөд Сангийн сайдын 2017 оны 36 дугаар тушаалын 1.16 дэх заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өглөө. Татварын хэлтсийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөцийг бүрэн ашиглахгүй байна. Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт сайн боловч түүний ашиглалт, үр дүн, үр өгөөж хангалтгүй, жилийн эцсийн татварын өр зөрүүтэй, дотоод хяналт шалгалтаар ногдуулсан татварын өрийн барагдуулалт муу байна.

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн Татварын хэлтсийн дарга Ж.Баяр-Одоод арга хэмжээ авч хэрэгжүүлэх 4 зөвлөмж хүргүүлж, 145.8 сая төгрөгийн үр өгөөж бүртгэлээ.

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудад аудит хийх



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2017 онуудад хэрэгжсэн дуусаагүй орхигдсон барилга байгууламжийн судалгааг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-элтэс болон Дарханы Дулааны цахилгаан станц ТӨХК-уудаас авч нэгтгэн ҮАГ-ын ГАГ-т хүргүүлсэн.

Дархан-Уул аймгийн хэмжээнд дуусаагүй орхигдсон 83,034.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 барилга байгууламж, ажлын гүйцэтгэл 50-98 хувьтай байна.

3.3. “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”



Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Дархан-Уул аймагт 62,557.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй он дамжин хэрэгжиж байгаа 5 төсөл, арга хэмжээг 11,590.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Дээрх арга хэмжээнүүдийн 83.1 хувийг барилга, 16.9 хувийг эрчим хүчний байгууллагад хуваарилжээ. Дээрх ТАХ-ээс 2017 онд хэрэгжиж дуусах 3 төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 5/02 тоот тогтоолоор 2017 оны хөрөнгө оруулалтад 2,008.9 сая төгрөг баталжээ. Үүнээс хойш 4 удаагийн төсвийн тодотголоор өөрчлөлт оруулсан ба аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 9/05 тоот тогтоолоор төсвийн тодотгол хийн зардлын дээд хэмжээг 129 ТАХ-нд

Дархан-Уул аймагт 2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих нийт 4,313.2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргад эрх нь шилжиж ирсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 4,098.1 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 215.1 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар хийжээ.

Захиалагчаас ажлын даалгавар, материал ирээгүйгээс 7,7 хувь буюу 4 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалт хийгдээгүй байна.

Сангийн яамны Хууль, эрх зүйн газарт худалдан авах ажиллагааны талаар 2 гомдол ирсэн байна. Үүнд:

- “Дархан Секьюрити” ХХК-ний зүгээс Дархан сумын 13, 14, 16 дугаар багийг хяналтын камерын системд шилжүүлэх ажил, ДА-ОНӨГ/2017-36 дугаар бүхий тендерийн сонгон шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдаагүй.
- “Хас Жинст” ХХК-ний зүгээс Дархан сумын 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугамын засвар, спорт заалны засварын ажил, БСШУСЯ/2017-04008 дугаар бүхий тендерийн сонгон шалгаруулалт хууль тогтоомжийн дагуу явагдаагүй.

Аудитаар 417,7 сая төгрөгийн 4 албан шаардлагаас өгснөөс эхний хагас жилд албан шаардлагыг бүрэн барагдуулж ажиллаа.

3.4. “Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн”



Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 8 блок 9,016.17 мкв талбай бүхий эмнэлгийн барилга байгууламж, 22 тасаг нэгж, 384 ор, 529 ажилтантайгаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргадаг судалгаагаар гаргасан Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нэг эмч, сувилагчид ногдох хүний тоог 2016, 2017 оноор харьцуулахад аймгуудын дунджаас нэг их эмчид ногдох хүний тоо 42-66, нэг сувилагчид ногдох хүний тоо 20-32-оор тус тус бага байна. Харин их эмчийн тоо аймгуудын дунджаас 77-93-аар их байна.

Тус эмнэлэг 2016 онд 8,474.0 сая төгрөг батлуулснаас 8,458.2 сая төгрөг зарцуулж, 15.8 сая, 2017 онд 8,767.2 сая 8,744.0 сая төгрөг зарцуулж, 23.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ. Улсын төсвийн санхүүжилт тайлант онуудад бүрэн орж ирсэн бөгөөд 2016 онд 11.2 сая, 2017 онд 26.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна. Зардлыг бүлгийн дүнгээр авч үзвэл цалин хөлс 4.6-5.3 сая, тогтмол зардал 7.2-8.9 сая, эд хогшил худалдан авах зардал 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.3-0.7 сая, нэг удаагийн тэтгэмж 7.7 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Иргэдийн өргөдөл, гомдол болон судалгаанаас дүгнэхэд амбулатороор үйлчлүүлэгчдийн хувьд эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүй, цаг ашиглалтад сэтгэл хангалуун бус байгааг харуулж байна. Мөн цахим бүртгэлээс амбулаторийн үзлэгийн цаг олголт, үзлэг хийлгэсэн хүний тоог эмч тус бүрээр гаргахад өдөрт нэг эмч дунджаар 6-38 хүнд үзлэг хийсэн бол цаг олголт нь ажлын цагийн хуваарийн дагуу олгогддоггүй байна.



Тухайлбал ажлын цагийн хуваарь 8.00-14.00 байхад эрүү нүүрний эмчийн үзлэг 8.20-11.30, шүдний эмчийн үзлэг 8.00-12.30 хооронд олгогдсон бол 8.00-16.30 цаг хүртэл ажиллах ёстой дуран оношилгооны эмчийн үзлэг 8.00-12.30 хооронд цаг олгосон байв.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2016, 2017 онуудад хийж гүйцэтгэсэн тул тус аудитаар 2018 оны 1-5 дугаар сарыг хамрууллаа. Уг хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,098.4 сая төгрөгийн 23 гүйлгээг мэдээлээгүй байв. Мөн төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 26.1 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрээс 21.3 сая төгрөгийн 6 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна. Дээрхээс бусад мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн байршуулсан байв.

Аудит үргэлжлэн хийгдэж байна.

2018 онд нэгдсэн удирдамжаар 3, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрсдийн санаачилгаар 1 аудит хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс төлөвлөгөөнд туссаны дагуу өөрсдийн санаачилгат 1 аудит хийгдэж байна.

4.1. “ТӨХК-уудын худалдан авах ажиллагааг хэрхэн хуульд нийцүүлж явуулж байгаа байдал, үр дүн”



Аудитад “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК, “Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК, “Дархан АЗЗА” ТӨХК, “Дулаан шарын гол” ТӨХК, “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК, “Дархан Ус суваг” ХК-иудын 2016-2017 оны худалдан авах үйл ажиллагаа болон холбогдох баримт материалыг хамруулан шалгалт хийж байна.

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хувьцаат компаниуд худалдан авах ажиллагааны нийт дүнгээр 2016-2017 онд 20,884.2 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 18,852.2 сая төгрөгийн худалдан авалт хийж, 90.3 хувийн биелэлттэй байна.

Аудитаар худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг “Дарханы Дулааны Цахилгаан Станц” ТӨХК-иас бусад компаниуд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дүгээр зүйлийн 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байв.

Худалдан авах ажиллагааны дүнгээр байгуулсан нийт 797 ажлын 7,8 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 31.3 хувийг харьцуулалтын, 59.0 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулж, 1,9 хувь буюу 15 ажил, үйлчилгээ хийгдээгүй байна.

Аудит үргэлжлэн хийгдэж байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ-д 2, Төрийн албаны зөвлөлийн салбар хуралд 2 удаа тус тус зөвлөх эрхтэйгээр оролцлоо.

Аймгийн ИТХ захиалгаар “Аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагаа, үр дүн”-д төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгэлийн аудит хийгдэж, дүнг аймгийн ИТХ-ын даргад танилцууллаа.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 онд төлбөрийн актын талаар 3, байгууллагын санхүүгийн талаар дүгнэлт гаргах тухай 1, нийт 4 өргөдөл гомдол ирснийг шалгаж хариуг хугацаанд нь өглөө.

Дархан-Уул аймгийн аудитын газар www.audit.mn веб сайтаар 2018 оны эхний хагас жилд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг байршуулж олон нийтэд мэдээлэл өгч, мөн УАГ-аас зохион байгуулсан онлайн хуралд бүрэн оролцож, мэдээ тайлан, судалгааг шуурхай хүргэж ажиллаа.

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг гаргаж УАГ-ын Стратеги Удирдлагын газарт 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат оролцсон.

Аймгийн аудитын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан өндөр настнуудаа ахмадын баяр, цагаан сарын баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

2018 оны эхний хагас жилд Үндэсний аудитын газарт хүргүүлсэн судалгаа:

№	Судалгаа	Хаана	цахимаар/цаасаар	Хугацаа
1	Акт, албан шаардлагын судалгаа	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	1 сар
2	2017 онд тэтгэлэг авсан албан хаагчид	Тамгын газарт	gansukhl@audit.gov.mn	1 сар
3	Байгууллагын тоног төхөөрөмжийн	Тамгын газарт	anuudarib@audit.gov.mn	1 сар
4	Албан хаагчдын 2018 оны цалин нэмэгдлийн	Тамгын газарт	gansukhl@audit.gov.mn	1 сар
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2017 онуудад хэрэгжсэн дуусаагүй, орхигдсон барилга, байгууламжийн судалгаа	Гүйцэтгэлийн аудитын газар	tsolmonts@audit.gov.mn	1 сар
6	бүлгийн үйл ажиллагааны дүрэм"-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, үүнтэй холбогдон гарах тооцооллын	Ажлын албанд	bulgantuyae@audit.gov.mn	2 сар
7	Гэрээгээр аудит хийлгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулалт	Стратеги удирдлагын газарт		2 сар
8	Байгууллагын үндсэн хөрөнгийн	Тамгын газарт	saranu@audit.gov.mn	2 сар
9	Ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлээр мэргэшсэн албан хаагчдын мэргэжлийн зэргийн	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	2 сар
10	Албан хаагчдын 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	2 сар
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын судалгаа	Нийцлийн аудитын газарт	sugarmaa.s@audit.gov.mn	2 сар
12	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын судалгаа	Нийцлийн аудитын газарт	nyamtumurl@audit.gov.mn	2 сар
13	Орон нутаг дахь төсвийн шууд захирагчдын 2017 оны санхүүгийн тайланг аудитад хамруулсан талаар	Ажлын албанд	bulgantuyae@audit.gov.mn	3 сар
14	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын судалгаа	Гүйцэтгэлийн аудитын газар	lkhagvatserenb@audit.gov.mn	3 сар
15	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгууллагын талаар	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	4 сар
16	Ажиллагсдын цалинг дамжуулан олгож буй банк	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	4 сар
17	Сэлгэн ажиллах саналтай ажиллагсдын	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	4 сар
18	2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлийг төсвийн захирагч, төсөл хөтөлбөр, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	Санхүүгийн аудитын газарт	bayarbaab@audit.gov.mn	5 сар
19	ТЕЗ, түүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 11 хавсралт судалгаа	Санхүүгийн аудитын газарт	tsegmidorjid@audit.gov.mn	5 сар
20	Байгууллагын автомашины судалгаа	Тамгын газарт	saranu@audit.gov.mn	6 сар
21	2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар илэрсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн	Ажлын албанд	selengem@audit.gov.mn	6 сар

Үүний зэрэгцээ УАГ-т 2018 онд хийгдэх сургалтын талаар, Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Төрийн аудитын байгууллагын мэдээлэл, технологийн бодлогын баримт бичиг, Төрийн сангийн үйл ажиллагааны тогтолцоо, үр дүн сэдэв аудитад саналаа хүргүүлсэн.



ҮАГ-ын Стратеги удирдлагын газраас 2018 онд гаргасан Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууц хамгаалах журам, Онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам, Төрийн албаны нэмэгдэл олгох журам, Төрийн албан хаагчдад мэргэшлийн нэмэгдэл олгох түр журам, Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн СТА-ын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах загваруудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймгийн аудитын газрын ажилтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон ХОМ-ийн тайланг Авлигатай тэмцэх тухай хуулийн дагуу 02 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т хүргүүлсэн. Гэрээт аудитор Н.Отгонцэцэгийн урьдчилсан мэдүүлгийг ҮАГ-ын Хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлсэн.

Санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын үе шат бүрд чанарын хяналт хийж, тайланг баталгаажуулж, мөн гэрээгээр гүйцэтгэсэн аудитад чанарын хяналт тавьж, гэрээг дүгнэж ажиллалаа

ҮАГ-аас зохион байгуулсан Төрийн аудитын байгууллагын менежерүүдийн сургалтад аудитын менежер Ш.Мөнхбаяр, Төрийн аудитын байгууллагын ажилтны чадамжийн сургалтад ахлах аудитор Х.Сувдмаа, аудитор С.Санжаажав, Төрийн аудитын байгууллагын шинэ ажилтнуудын сургалтад аудитор Н.Отгонцэцэг нар тус тус хамрагдсан.

Монгол Улсын Сангийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтад аудитор С.Санжаажав, Ч.Гантулга нар хамрагдаж, сертификат гардан авсан.

Мөн ШУТИС-ийн англи хэлний багш Б.Сувд-Эрдэнэтэй гэрээ байгуулан 2018 оны 04 сарын 01-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ны хооронд 7 хоног бүрийн даваа, лхагва гаригуудад англи хэлний ярианы болон сонсголын нийт 16 удаагийн хичээл заалгуулж, нийт албан хаагчид хамрагдсан.

ММНБИ-ийн эрх олгох сургалтад аудитор С.Санжаажав, Г.Батмягмар хамрагдаж, эрх олгох шалгалт өгч, аудит, хуулийн шалгалтад хөнгөлөлтөд аваад байна.

Төрийн болон албаны тухай хуулийн дагуу байгууллагын нууцын ажилтан Ш.Мөнхбаяр, 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар 322, 330 дугаар цэргийн ангиудад аудит хийх С.Батцэцэг нарыг Дархан-Уул аймгийн Тагнуулын хэлтэст хүсэлт гарган Аюулгүйн байдлын шалгалтад хамрагдаж аюулгүй байдлын гэрчилгээ гардан авсан.

Тагнуулын ерөнхий газрын Дархан-Уул аймаг дахь хэлтсийн даргын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн н18/44 тоот албан бичгийн хариуг (байгууллагын нууц хамгаалах ажилтны тайлан, мэдээ) хүргүүлэв.

Мөн манай хамт олон Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан волейболын тэмцээнд амжилттай оролцож алтан медалийн эзэд болсон.



Улсын Их хурлын харьяа байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Их хурлын цом-2018” тэмцээнд волейболын төрөлд аудитын менежер Ш.Мөнхбаяр, хөл бөмбөгийн төрөлд аудитор Г.Батмягмар нар амжилттай оролцож хүрэл медалийн эзэд боллоо.

Аймгийн Аудитын газарт тогтвор суурьшилтай, өндөр амжилт гарган ажиллаж байгаа аудитор У.Батсүрэн “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулав



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Бүх нийтээрээ мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд хамт олноороо оролцож мод тарьлаа.

Дорноговь аймаг дахь дэлхийн энергийн төв Хамрын хийдэд хамт олноороо аялал хийж, энерги авлаа.



“Санхүүгийн тайлангийн аудит”

2018 оны 01 дүгээр сарын 19

Ахлах аудитор С.Батцэцэг

Санхүүгийн
тайлангийн аудитЧБА, дотоод аудитаас
өгсөн зөвлөмж

- ▶ Хүснэгт бүрийн дээр мөнгөн дүнг илэрхийлсэн нэгжийг бичих. /млн.төг, сая.төг/
- ▶ Тоонуудаа хамгийн суурийн тооны өмнө цэг, бусад нь таслалаар бичих. Ж: 1,234,567.80
- ▶ Төсвийн гүйцэтгэлийн тайланг орон тоотой авах.
- ▶ Байгууллага бүрт асуудлын бүртгэл хөтлөх.
- ▶ Мөнөхмөнтийн захидал бичих.
- ▶ СТАУС програмын санал солилцох талбараар харьцах.
- ▶ Зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттайгаар авах.
- ▶ Хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт өгөх болон санал дүгнэлт өгөхөөс татгалзах.

Анхаарах асуудлууд

- ▶ Аудитын ажлын захицлыг хүргүүлэх /2017.10.31/
- ▶ Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гаргах
- ▶ Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах
- ▶ Төсвийн менежертай хийсэн уулзалтын тэмдэглэл хөтлөх
- ▶ Санхүүгийн тайлан, холбогдох баримт материал ирүүлэхдээ аудит хийлгэхийг хүссэн албан тоот /...байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, баримт материалыг хүргүүлэх, аудит хийх өгнө үү-ыг хүлээн авах
- ▶ Шварслэгетэй баримт материалын хяналтаар материалыг хүлээн авч, нягтлан бодогчоор гарын үсэг зуруулах
- ▶ Загвар өхсөл-ээ авах.
- ▶ Аудитын төлбөрийг хэзээ, ямар дансанд тушаасныг тэмдэглэх.

УИХ-ын 2017.04.14-ний
29 дүгээр тогтоол

- ▶ 1.4 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх
- ▶ 1.5 Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах

Сангийн Сайдын 2017 оны
36 дугаар тушаал

- ▶ 1.1.а/ төрийн албан хаагчид зэрэг дэв олгох буюу зэрэг дэв ахиулах шийдвэрийг 2017.05.01-2019.12.31 хүртэл гаргахгүй байх
- ▶ 1.1.б/ Төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг 2017.05.01-2019.12.31 хүртэл түр зогсоох талаар харьяа төсөвт байгууллагын төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарт үүрэг, чиглэл өгөх

Сангийн Сайдын 2017 оны
36 дугаар тушаал

- ▶ 1.1.в/ 2017.05.01-2018.12.31 хүртэл хугацаанд зөвхөн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ буюу төрийн өмчийн бүх шатны сургууль, эмнэлэг, цэцэрлэгийн байгууллагаас өндөр насны тэтгээрт гарах 2 албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилж ба үүнд эрүүл мэнд, боловсролын салбарын захираганы байгууллагыг хамруулахгүй байх
- ▶ 1.1.г/ дээр дурдсанаас бусад бүх салбарт нөхөн томилж хийхгүйгээр ажилтны ажил, үүргийн хуваарийг шинэчлэн тогтоох замаар ачааллыг нягтруулах, хэрэв зайлшгүй шаардлагатай орон тоо нөхөн томилж шаардлагатай тэм үзвэл ТЭЗ-ийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах

Сангийн Сайдын 2017 оны
36 дугаар тушаал

- ▶ 1.2 Өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн урсгал зардлын хэмжээний горимыг 2017-2019 онд хэрэгжүүлнэ. Үүнтэй холбогдуулан дараах зүйлсийг анхаарах:
а/ албан ажлын зайлшгүй шаардлага гарч, дээд шатны удирдах байгууллага, албан тушаалтны албан ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд гадаад томилолтын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх
б/ албан тушаалтны гар утас худалдан авах болон гар утасны ярианы зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх
в/ тавилга шинээр худалдан авахгүй байх
г/ эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх

Сангийн Сайдын 2017 оны
36 дугаар тушаал

- д/ төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх
- е/ төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээ зохион байгуулах, цаасан мөндчилгээ нийлэх, баяр ёслол, ой тэмдэглэх зорилгоор бэлэг дурсгалын зүйлс, календарь зэрэг зүйлс бэлтгэх, илгээ тэтгэхийг хориглох.
- ё/ төсвийн хөрөнгөөр гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх
- ж/ төсвийн хөрөнгөөр салбар болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор баримтаг болон уран сайхны кино хийлгэх, телевизийн уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх

Сангийн Сайдын 2017 оны
36 дугаар тушаал

- з/ эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, өвчлөгтэй тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, батлан хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсөвт байгууллага албан ажлын хэрэгцээнд нэгээс илүү автомашин хэрэглэхгүй байх
- и/ салбарын хэмжээний сургалт, семинар, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэргээр томилолтын зардлаа хэмнэх, бууруулах

УИХ-ын 2017.11.09-ны
67 дугаар тогтоол

- 1.1. 2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300 000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох

ЗГ-ын 2017.12.06-ны өдрийн 52
дугаар тэмдэглэлд:

“... сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав”.

“Төрийн аудитын байгууллаганы ажилтны ёс зүйн дүрэм”

2018 оны 01 дүгээр сарын 26




Аудитын менежер Ш.Мөнхбаяр

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ ▶ Монгол улсын ерөнхий аудиторын 2003 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 тоот тушаалаар төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг анх баталсан. ▶ Монгол улсын ерөнхий аудиторын 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 131 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.
Ерөнхий зүйл Төрийн аудитын үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, бодитой байх зэрэг үндсэн зөрчмүүдийг ягштал мөрдүүлэх, төрийн аудитын хараат бус, найдвартай байдлыг хангуулах, төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг сонирхлын болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино. Хувийн амьдралдаа ямар нэг зүй бус үйлдэл, ёс суртахуунгүй байдал гаргахгүй байж өөрийн буюу байгууллага, хамт олон, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалж байх үүрэгтэй.	Итгэл, найдвар хүлээх шаардлага Төрийн аудитын байгууллага, түүний ажилтны ажил, аудитын дүн, санал дүгээлт шударга, бодитой, алдаа мэддэггүй гэдэгт УИХ, ЗГ, шалгагдсан байгууллага, олон нийт итгэлтэй байх нөхцөлийг хангахын хамт тэдний арга ажиллагааг аливаа хараагаас сардалж, шүүмжлэлд өртөхгүй байх шаардлагатай. Төрийн аудитын байгууллагын ажилтан удирдах, удирдуулах ёс, төрийн албаны дүрэм журмыг мөнд сахин, бие биенээ харилцан хүндэтгэж, өөр хоорондоо нөхөрсөг, шударга, хамтат, ажил хэрэгч харилцаатай байна. Бусад ажилтны аудитын дүн, дүгээлтэд нөлөөллийг хориглоно. Төрийн аудитын байгууллагын ажилтан удирдах ажилтны хуульд нийцсэн шийдвэр, үндэслэл бүхий зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.
Хараат бус байдлыг хангах шаардлага -Төрийн аудитын байгууллагын ажилтан албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө шалгагддаг байгууллага, холбогдох бусад этгээдээс мөнгөн үнэ цэн бүхий бэлэг, дурсгалын зүйл, шан харамж авах, өөртөө болон гэр бүл, ах дүү, төрөл садандаа үнэгүй буюу хөнгөлттэй үйлчилүүрхээс татгалзах замаар сонирхлын болзошгүй зөрчлөөс зайлсхийж, хараат бус байдлаа хамгаалах ёстой. -Аудитын холбогдолтой уулзалт, ярилцлага хийх, томилолтоор ажиллах явцад цай, кофегээр дайрсан тохиолдолд, байгууллагын нэр, эмблем бүхий танилцуулга, үзэг, хараандаа, дээтэр, хуанли зэрэг сурталчилгааны материалог зөвхөн хүтээн авч болно.	Хараат бус байдлыг хангах шаардлага ТАБ-ын ажилтан албан үүргээ үр дүнтэй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд нь харшлах өөр ажил, үйл ажиллагааг цалинтай, цалингүй хэлбэрээр ажлаас гадуур гүйцэтгэж болохгүй. ТАБ-ын ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ архи, согтууруулах ундаа хэрэглэх, шалгагддаг байгууллагын ажилтнуудаар зочлуулж дайллуулах, зугаа цэнгээний арга хэмжээнд нь оролцохыг хориглоно.
Хараат бус байдлыг хангах шаардлага -Төрийн аудитын байгууллагын ажилтан албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө шалгагддаг байгууллага, холбогдох бусад этгээдээс мөнгөн үнэ цэн бүхий бэлэг, дурсгалын зүйл, шан харамж авах, өөртөө болон гэр бүл, ах дүү, төрөл садандаа үнэгүй буюу хөнгөлттэй үйлчилүүрхээс татгалзах замаар сонирхлын болзошгүй зөрчлөөс зайлсхийж, хараат бус байдлаа хамгаалах ёстой. -Аудитын холбогдолтой уулзалт, ярилцлага хийх, томилолтоор ажиллах явцад цай, кофегээр дайрсан тохиолдолд, байгууллагын нэр, эмблем бүхий танилцуулга, үзэг, хараандаа, дээтэр, хуанли зэрэг сурталчилгааны материалог зөвхөн хүтээн авч болно.	Хараат бус байдлыг хангах шаардлага ТАБ-ын ажилтан албан үүргээ үр дүнтэй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд нь харшлах өөр ажил, үйл ажиллагааг цалинтай, цалингүй хэлбэрээр ажлаас гадуур гүйцэтгэж болохгүй. ТАБ-ын ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ архи, согтууруулах ундаа хэрэглэх, шалгагддаг байгууллагын ажилтнуудаар зочлуулж дайллуулах, зугаа цэнгээний арга хэмжээнд нь оролцохыг хориглоно.
Хараат бус байдлыг хангах шаардлага - ТАБ-ын ажилтан сонхуугийн болон сонхуугийн бус сонхилсон бүхий байгууллага, илгээгч, үйл ажиллагаанд оруулж хийхэд оролцож болохгүй. - Аж ахуйн нэгж, байгууллагын хувьцаа эзэмшигч нь байх - Тухайн байгууллагаас ямар нэгэн төрлийн цалин хэлбэр, тэтгэвэр татгалж авдаг байх - Тухайн байгууллагын үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан, түүнээс орлого олдог байх - Эцэс, нөхөр, хүүхэд нь тухайн байгууллагад ажилладаг байх - Тухайн байгууллагад ажилтан, засвар, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, зөвлөхөөр дотоор ажилладаг байх	Улс төрийн хувьд төвийг сахих шаардлага Төрийн аудитын байгууллага, түүний ажилтан чиг үүргээ шулуун шударга хэрэгжүүлэхийн тулд улс төрийн нөлөөнөөс хараат бус байж, улс төрийн хувьд төвийг сахина.

“Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрэм”

2018 оны 02 дугаар сарын 02

Аудитын менежер Ш.Мөнхбаяр



“ТАБ-ын албан хаагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэх ёс зүйн ерөнхий хэм хэмжээ”

2018 оны 02 дугаар сарын 09

Аудитын менежер Ш.Мөнхбаяр



2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар илэрсэн
залруулагдсан болон залруулагдаагүй НББ-ийн бичилт №01

2018 оны 03 дугаар сарын 16

Аудитор У.Батсүрэн

Санхүүгийн тайланг баталгаажуулах
аудитаар илэрсэн залруулагдсан болон
залруулагдаагүй НББ-ийн бичилт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Залруулсан алдаа:

1. ҮХ-ийн элэгдэл буруу тооцсон.
2. Зөвхөн ӨХЗ шийдвэрээр ЭХ акталсан
3. Удирдлагын шийдвэргүйгээр ЭХ /АШБ-гүй/ данснаас хассан.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Залруулагдаагүй алдаа:

1. ТАХ-д олгох нэг удаагийн урамшлын зардлаас ХХОАТ төлсөн.
2. Албан хаагчдад илүү цагийн хөлс олгохдоо дотоод журмыг мөрдөөгүй.
3. Сонгуулийн зардлаас хоол унаа, шатахууны зардал илүү олгосон.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

4. Авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
5. Өөр байгууллагын ажилтнуудад томилолтын хөлс, мөн өнгөрсөн оны томилолт олгосон.
6. Батлагдсан төсвөөс шүүхийн шийдвэрээр цалин нөхөн олгосон.

ХОНГОР СУМЫН ЗДТГ

Залруулсан алдаа:

1. ҮХ бэлтгэхэд зарцуулсан зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн.
2. АШБ-гүй ажил гүйлгээ бүртгэсэн. Өвчнөөр хорогдсон малыг БҮЗ дансанд бүртгэсэн.
3. Хандивын хөрөнгийг дутуу бүртгэсэн.

ХОНГОР СУМЫН ЗДТГ

Залруулагдаагүй алдаа:

1. Албан конторт урсгал засвар хийсэн.

ХХҮГ

Залруулсан алдаа:

1. Мөнгөн гүйлгээний тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн.

ХХҮГ

Залруулагдаагүй алдаа:

1. Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад үр дүнгийн урамшуулал олгосон.
2. Шийдвэргүйгээр илүү цагийн хөлс олгосон.
3. Шийдвэргүйгээр цалингийн шатлал ахиулсан.
4. Мэргэшсэн жолоочийн нэмэгдэл олгосон.
5. ТЗ-ны албан хаагчид үр чадварын нэмэгдэл олгосон.
6. Авлага, өр төлбөр үүсгэсэн.

ХАЛАМЖИЙН САН

Залруулсан алдаа:

1. Өмнөх үеийн үр дүнг буруу тайлагнасан.

Залруулагдаагүй алдаа:

1. Төсвийг хэт өндөр төлөвлөсөн.
2. Халамжийн сангаас бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн.

БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТ

Залруулагдаагүй алдаа:

1. Хөлсөөр ажиллах гэрээг зөрчиж, үр дүнгийн урамшил олгосон.
2. Бичиг хэрэг, түлш шатахууны материалыг шууд зардлын дансанд бүртгэсэн.
3. Үндсэн хөрөнгийг тайлант үеийн зардлаар тайлагнасан.

